

Мод боловсруулалт, ашиглалт



Эрт дээр үеэс хүмүүс модыг юунд ашиглаж ирсэн талаар та үүнээс өмнө бодож байсан уу? Мод байгаагүй бол хүмүүс түлэх түлээгүй, амьдрах орон гэргүй, ажлын багаж хэрэгсэлгүй байх байсан байх даа. Байшин барих байтугай гэрийн мод ч хийхэд хэцүү. Ингээд бодохоор амьдралыг модгүйгээр төсөөлөхийн аргагүй.

Тэгэхээр мод хангалттай байх нь бидэнд чухал байгаа биз. Тийм болохоор бид ойжуулалт хийж, ойг арчлан хамгаалдаг юм. Мод нь байгалийн нөхөн сэргээгддэг материал болохоор хүн төрөлхтөн оршин тогтнож байгаа түүхийн бүхий л хугацаанд ашиглаж иржээ. Бидний өвөг дээдэс модыг аль болох олон талаар ашиглахын тулд зөв боловсруулах арга барилд суралцжээ.

Модыг боловсруулж
банз, модлог шахмал
хавтан, цаас
үйлдвэрлэдэг.

Банз үйлдвэрлэх

- хөрөө рам болон түүзэн хөрөөн дээр бөөрөнхий модыг уртааси нь зүсэж банз үйлдвэрлэдэг
- зүссэн банзгаа хатаалгын цех эсхүл наранд хатаана



Намайг гоёхон мод
хэмээн магтах нь
надад ихэд таатай
байна!



Банзны төрөл

- банз
- зүсмэл банз
- хагас зүсмэл банз
- жижиг банз

Банз

Банзны өргөн нь зузаанаасаа 2 дахин илүү байдаг. Нэг үгээр хэлэхэд хавтгай хэлбэртэй гэсэн уг. Банзыг дараах байдлаар ангилана:

- банзны зузаан 40 мм-ээс их
- банзны зузаан хамгийн ихдээ 40 мм
- зах банз – зузаан нь хамгийн ихдээ 25 мм
- зах банзны – зузаан нь хамгийн ихдээ 25 мм бөгөөд зүүн талын зах
банзыг уртааш нь хөрөөдсөн байх

Зүсмэл банз

Зузаан нь өргөнөөсөө хоёр дахин их, тэгш өнцгөөр зүссэн.

- дүнз – хөндлөн огтлолын хэмжээс нь 100 cm² их байх
- дүнэнцэр – хөндлөн огтлолын хэмжээс нь 25 – 100 cm²
- банз – хөндлөн огтлолын хэмжээс нь 10 cm² бага байх



Хөрөө рам-д банз, дүнэнцэр гадна төмөр замын дэр мод, паркет болон хуулга үйлдвэрлэдэг.

Модны ашиг
тус нь энд
нэрлэснээр
зогсохгүй...

- хүрээлэн буй орчинд ээлтэй нөхөн сэргээгддэг түүхий эдэд тооцогддог. Бусад үнэт түүхий эдийг бүрэн орлох чадвартай. Иймдээ ч модыг 21 зууны материал гэж үзэж байгаа билээ!
- манай гаригийн хүн нэг бүрд 1 m³ заруу ой ноогдож байна.
- Гурван ам бүтэй айлд 80 жилийн хугацаанд шинээр ургаж байгаа 240 m³ шинэ ой оногдож байна. Үүний 140 m³ modoор нь дулаалга сайтай байшин барьж 80 жилийн турш түлшинд хэрэглэнэ гэж бодоход үлдэж байгаа 100 m³ модыг нь тавилга, хөгжмийн зэмсэг, чөлөөт цагаа өнгөрөөх бусад зүйлд хэрэглэх боломжтой юм.

